

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ШААРДАГДАХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС:

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛҮҮЛЭХЭД:

1. Өргөдөлөө “Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар ойлгомжтой цэгцтэй бичиж, холбоо барих утасны дугаар, гэрийн хаяг, өргөдөл гаргасан он сар өдрийг заавал бичнэ.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТАД БҮРТГҮҮЛЭХЭД

1. Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албан хаагчийн анкетыг маягт N1-ийн дагуу бүрэн бөглөсөн байх);
2. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
3. Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;
4. Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт;
5. “4 x 6”-гийн хэмжээний цээж зураг 2 хувь;
6. Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтэр/-ийн эх хувийг хуулбарын хамт
7. Шалгалтын үйлчилгээний төлбөр 6000₮

ХОЁР.ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭС:

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН АРХИВЫН ТАСГААС ЛАВЛАГАА АВАХАД

1. Иргэний үнэмлэх \хуулбар байж болно\
2. Хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр
3. Үзэг
4. Цэргийн алба хаасан бол цэргийн батлах, байхгүй бол алба хаасан оныг мэдэж байх
5. Хөдөлмөрийн дэвэтр байхгүй бол ажилд орсон гарсан он, ажиллаж байсан байгууллагаа цаасан дээр тэмдэглэж ирэх
6. Малчин бол хэдэн онд өрх тусгаарласан, мөн хэдэн онд мал дээр гарснаа зайлшгүй мэдэж байх шаардлагатай
7. Архивын лавлагаа авсан төлбөр: Тушаал 2500, цалингийн цэс 2000, үйлчилгээний цэс 1000 төгрөг тус тус болно.

ГУРАВ.ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД

1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой дурьдах/;
2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;
3. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;
4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
5. Тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг;
6. Аймгийн Засаг даргын саналыг авсан байна.

ГУРАВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН ТАСЛАХ КОМИССООС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД

1. Хөдөлмөрийн маргааны талаар тодорхой ойлгомжтой бичсэн өргөдөл
2. Өргөдлийг хянан үзэхэд зайлшгүй шаардлагатай номтлох баримтууд

ДӨРӨВ. ЦЭРГИЙН ШТАБ

ЦЭРГИЙН АЛБА ХААСАН ТУХАЙ АРХИВЫН ЛАВЛАГАА

1. Өргөдөл
2. Архивын лавлагаа авсан төлбөр 4000 төгрөг

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР